



**ЖАМБЫН ДАШДОНДОГ (1941-2017)**

**Төрсөн нутаг:**

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт төржээ.

**Гол уран бүтээл:**

"Аранзал зээрд", "Вансэмбэрүү", "Чулуун домог", "Аав, ээж, би" зэрэг хүүхдийн зохиолын олон түүвэр хэвлүүлжээ.

**Зохиолчийн хэлсэн онцлох үг:**

Би хүүхэд гэдэг бурхан шүтдэг.

“ Аранзал зээрд ”

## АРАНЗАЛ ЗЭЭРД

Аранзал зээрд морио  
Алхуулан шогшууллаа  
Шогшуулснаа хатирууллаа  
Хатируулснаа ергүүлээ  
Ергүүлснээ цогиуллаа  
Цогиулснаа давхиуллаа.  
Талаар талаар  
Ташуур өгөн  
Ташуур өгөн  
Довтолгов.  
Замаар замаар  
Тоос босгон  
Тоос босгон  
Хурдалгав.  
Хатан дэлхий  
Дөрвөн туурай  
Дөрвөн туурай  
Бөмбөрдөнө.  
Хайр чулуу  
Арван зүгтээ  
Арван зүгтээ  
Цацагдана

Хөрст дэлхий  
Хөлийн доор  
Хөлийн доор  
Жирэлзэнэ.  
Хөтөл гүвээ  
Холын холд  
Холын холд  
Торолзоно.  
Сумын бараа  
Тодорлоо  
Тодорлоо  
Сургуулийн байшин  
Ойртлоо  
Ойртлоо  
Аранзал зээрд мориныхоо  
Амыг татан цогиуллаа  
Цогиулснаа ергүүлээ  
Ергүүлснээ хатирууллаа  
Хатируулснаа шогшууллаа  
Шогшуулснаа алхууллаа.

(Жамбын Дашдондог, Аранзал зээрд,  
УБ., 1993, 125-126 дугаар тал)

Дараах үгийн утгыг тайлбарлаарай.



шогшуулах



цогиулах



ергүүлэх



давхиулах

## Асуултын дагуу ярилцаарай.

Хүүхэд юунд яарч байна вэ?

Шүлгийн аль хэсэгт хурдан уншмаар санагдаж байна?

Хурдан унших үед чамд юу мэдрэгдэж байна?

Морь унаж яваа хүүгийн ямар сэтгэл хөдлөлийг харуулсан байна вэ?

Шүлэгт юуны тухай өгүүлэв?

- Шүлгийн эхэнд хүү яагаад уян дээрээсээ морио алхуулаад гарав?
- Зохиолын төгсгөлд бас сум, сургуулийн барааг хараад мориныхоо амыг татаад, явдлыг удаашруулав?
- Энэ ямар ёс заншилтай холбоотой вэ?

## Шүлгийн хэл, уран сайхныг задлан шинжилж, далд утгыг тайлбарлаарай.

Аранзал зээрд мориныхоо  
Амыг татан цогиуллаа  
Цогиулснаа ергүүлээ  
Ергүүлснээ хатирууллаа  
Хатируулснаа шогшууллаа  
Шогшуулснаа алхууллаа.

давхиулах  
цоглуулах

хатируулах

ергүүлэх

шогшуулах

алхуулах

Үг хэлээр хүний сэтгэлийн хөдөлгөөн, үйлийн явц, өрнөлийг багаас их рүү эрчимжүүлэн ахиулж илэрхийлэх давталтын өвөрмөц хэлбэрийг ахиулал гэнэ.

Аранзал зээрд морио  
Алхуулан шогшууллаа  
Шогшуулснаа хатирууллаа  
Хатируулснаа ергүүлээ  
Ергүүлснээ цогиуллаа  
Цогиулснаа давхиуллаа.

давхиулах  
цоглуулах

хатируулах

ергүүлэх

шогшуулах

алхуулах

Үйл явц, хүний сэтгэлийн хөдөлгөөн, өрнөлийг ихээс бага руу нь буурах дарааллаар зохион байгуулж найруулахыг бууруулал гэнэ.

Хайр чулуу  
Арван зүгтээ  
Арван зүгтээ  
Цацагдана.  
Хөрст дэлхий  
Хөлийн дор  
Хөлийн дор  
Жирэлзэнэ.

Уран сайхны зорилгоор, үг, хэллэг, өгүүлбэр, шад, бадгийг дахин давтах ур маягийг уран давталт гэнэ. Энэ нь хэмнэл тааруулах, зохиолын баатрын хувийн онцлогийг гаргах, уран сайхны илэрхийллийн үүрэгтэй.

Эдгээр ур маягуудыг хэрэглэснээр зохиолын утгад яаж нөлөөлж байна вэ?



## Гэрийн даалгавар

Өөрийнхөө хамгийн яарч, тэмүүлж, догдолж байсан үеийн сэтгэл хөдлөлийг ахиулал, бууруулал, уран давталт ашиглан дүрсэлж, шүлэг зохиогоорой. Аранзал зээрд шүлгийн хэлбэрийг дуурайгаарай.